



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/540

Номгон

「Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний
үйл ажиллагаанд онлайн систем нэвтрүүлж,
цахим санд шилжүүлэх тухай


Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үр дүнд хүргэх, хяналтыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5. "в", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар бүлгийн 2.1.1, 2.1.2 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хяналт шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд онлайн систем нэвтрүүлж, цахим санд шилжүүлэх, программ хангамжийг хийлгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Мандал) -д үүрэг болгосугай.

2. Аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг хийлгэхэд шаардагдах 45 000 000 (Дөчин таван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал) -д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН